

ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Төв банк (Монголбанк) -ны тухай хуулийн 5, 21 дүгээр зүйлүүдийг үндэслэн гадаад валютын улсын нөөц (цаашид Нөөц гэнэ)-ийн удирдлагын зорилго, хөрөнгө оруулалтын бодлого, эрсдэлийн удирдлагын зарчмууд, нөөцийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц, нөөцийн удирдлагад оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлоход энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. Нөөцийн удирдлагын зорилго

2. Нөөцийн удирдлагын зорилго нь:
 - 2.1. Нөөцийг төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл болгон ашиглах;
 - 2.2. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзэлийн үед ханшийг тогтворжуулахад шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;
 - 2.3. Улсын богино хугацаат гадаад валютын зээлийн төлбөрийг гүйцэтгэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлэхэд тус тус оршино.

ГУРАВ. Хөрөнгө оруулалтын бодлого

- 3.1 Нөөцийн удирдлагыг хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хэрэгжүүлнэ. Хөрөнгө оруулалтын бодлого нь нөөцийн найдвартай байдлыг хангах, нөөцийн түргэн хөрвөх чадварыг хангах, дээрх нөхцлүүд бүрэн хангагдсан тохиолдолд нөөцийн үр өгөөжийг хангах гэсэн зарчмаар хэрэгжинэ.
- 3.2 Нөөцийн удирдлагын зорилгод нийцүүлэн тухайн нэг хөрөнгө оруулалтын дунд ба урт хугацааны эрсдэл/үр өгөөжийн хүлээлт болон валютын ханшийн дунд ба урт хугацааны хүлээлт зэрэгт үндэслэн хөрөнгө оруулалтын бодлогыг боловсруулна. Богино хугацааны зах зээлийн хүлээлт нь хөрөнгө оруулалтын бодлого боловсруулахад нөлөөлөхгүй.
- 3.3 Нөөцийг нэг багц хэлбэрээр удирдах ба нөөцийн үр өгөөжийг хэмжих нэгж нь ам доллар байна.
- 3.4 Нөөцийн бүтцийг багцын ерөнхий бүтэц, гадаад валютын бүтэц, түүний хэлбэлзэж болох хэмжээ, хөрөнгө оруулалтын бүтэц, түүний хэлбэлзэж болох хэмжээ, урт хугацаат үнэт цаасны үргэлжлэх хугацаа, түүний хэлбэлзэж болох хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр тус тус Эрсдэлийн

удирдлагын албаны саналыг үндэслэн нэгдүгээр хавсралтын дагуу жил бүр баталж, мөрдүүлнэ.

- 3.5 Нөөцийн үр өгөөжийн жишиг хэмжүүр /бенчмарк/-ийг ерөнхий бүтэц, эрсдэлийн үнэлгээг үндэслэн хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр Эрсдэлийн удирдлагын албаны саналыг үндэслэн нэг жилээр тогтоон нэгдүгээр хавсралтын дагуу баталж, мөрдүүлнэ.
- 3.6 Нөөцийг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимит, лимитийн гүйцэтгэлийг тооцох хувийг тус тус Эрсдэлийн удирдлагын албаны саналыг үндэслэн хоёрдугаар хавсралтын дагуу улирал бүр баталж, мөрдүүлнэ.
- 3.7 Хөрөнгө оруулалтын бодлогыг улирал бүр нягтлан дүгнэх ба дэлхийн голлох орнуудын эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн өөрчлөлтөөс хамааран валютын ханш, хүүний түвшинд огцом хэлбэлзэл гарах нөхцөл үүсвэл хөрөнгө оруулалтын бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг Эрсдэлийн удирдлагын албаны саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
- 3.8 Гадаад орны банк, санхүүгийн байгууллагыг 3.6-д дурьдсан жагсаалтанд шинээр оруулах, лимит олгох, батлагдсан жагсаалтаас хасах асуудлыг тодорхой нөхцөл байдал, хэрэгцээ шаардлага, тухайн банк, санхүүгийн байгууллагын санхүүгийн үзүүлэлтүүдийг харгалзан Эрсдэлийн удирдлагын алба болон Валют, эдийн засгийн газрын саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

ДӨРӨВ. Хөрөнгө оруулалтын хэрэгсэлүүд

- 4.1 Монголбанк нь нөөцийг дараахь хөрөнгө оруулалтанд байршуулж, удирдана. Үүнд:
 - 4.1.1 Үнэт цаас. Дэлхийн гол хөрөнгийн биржүүд болон бусад зохион байгуулалттай зах зээлд тогтмол арилжаалагдаж, зах зээлийн үнээр үнэлэгдэж байдаг 5 жил хүртэлх хугацаатай дараахь үнэт цааснуудад хөрөнгө оруулалт хийж болно.
 - Урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй гадаад орны Засгийн газрын үнэт цаас,
 - Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас,
 - AAA зэрэглэлтэй гадаад орны Засгийн газрын баталгаатай байгууллагуудын AAA зэрэглэлтэй үнэт цаас.
 - 4.1.2 Богино хугацааны арилжаалагддаггүй хөрөнгө оруулалтын хэрэгсэлүүд. Ийм төрлийн хөрөнгө оруулалтын хугацаа нь 6 сараас хэтрэхгүй байна.

- Олон улсын төлбөр тооцооны банкинд байрших хугацаатай хадгаламж,
- Урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй гадаад орны банк, санхүүгийн байгууллагад байрших хугацаатай хадгаламж,
- Монголбанкны харилцах данс байршиж байгаа гадаад орны төв банк болон урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй гадаад орны банк, санхүүгийн байгууллагатай хийсэн урвуу репо хэлцэл ба репо хэлцэл. Эдгээр хэлцлийн барьцаанд авах үнэт цаас нь урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй гадаад орны Засгийн газрын үнэт цаас эсвэл урт хугацааны AA+ дээш зэрэглэлтэй гадаад орны банк, санхүүгийн байгууллагын AAA зэрэглэлтэй үнэт цаас байна.

4.1.3 Биет болон биет бус хэлбэрээр байршуулсан алт.

Алтыг биет хэлбэрээр зөвхөн Английн төв банкинд байршуулна. Биет бус хэлбэрээр алтыг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллага нь урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй байна.

Нөөцөд байгаа алтны тодорхой хэсгийг барьцаатай тохиолдолд 2 жил хүртэл хугацаагаар зээлдүүлж болно. Алтны зээлийн үйл ажиллагаанд оролцох гадаад орны банк санхүүгийн байгууллага нь урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй байна.

4.1.4 Санхүүгийн үүсмэл хэрэгсэлүүд.

Нөөцийн удирдлагын хүрээнд хүүний болон валютын своп хэлцэл, гадаад валютын форвард, хүүний фьючерс хэлцэл зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгсэлүүдийг ашиглаж болно. Ийм төрлийн харилцаанд оролцох харилцагч гадаад орны банк, санхүүгийн байгууллага нь урт хугацааны AAA зэрэглэлээс AA- хүртэлх зэрэглэлтэй байна.

4.1.5 Америкийн Нэгдсэн Улс, Япон, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Англи, Швейцари улсын Төв банкинд дахь харилцах данс, хоёр талын тохиролцоогоор хийх хөрөнгө оруулалт

4.1.6 Касс дахь бэлэн валют

4.2 Нөөцийг байршуулах хөрөнгө оруулалтууд нь ам доллар, евро, иен, фунт стерлинг, швейцарь франкаар илэрхийлэгдсэн байна.

4.3 Нөөцийг хөрвүүлэх үйл ажиллагаа нь дотоодын зах зээлд сөрөг нөлөө үзүүлэхээр бол нөөцийг дотоодын банк, санхүүгийн байгууллагуудад

хадгаламж хэлбэрээр байршуулах, тэдгээр банк, санхүүгийн байгууллагуудын гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулахыг хориглоно.

- 4.4 Улс орон, банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтууд нь Standard & Poor's, Fitch Ratings, Moody's гэсэн зэрэглэл тогтоогч 3 байгууллагын хамгийн багадаа 2 байгууллагаар зэрэглэл тогтоолгосон байна. Хэрэв зэрэглэл нь зөрүүтэй тохиолдолд бага зэрэглэлээр авна.

ТАВ. Эрсдэлийн удирдлага

- 5.1 Монголбанк нь өөрийн болон бусдын эзэмшилд (нөөцийн удирдлагыг гадаадын банк, санхүүгийн байгууллагаар хийлгэх) байгаа нөөцийн удирдлагаас хүлээж болох алдагдлыг нөхөх хангалттай өөрийн хөрөнгөтэй байх ба түүнийг хүлээж болох эрсдэлүүдэд тархаан хуваарилсан байх ёстой.
- 5.2 Нөөцийн удирдлагын хүрээнд гарч болох дараахь эрсдэлүүдийг удирдан зохицуулна. Үүнд:

5.2.1 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага:

- Нөөцийг АНУ, Евро бүс, Японы валютууд болон тэдгээрээр илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгсэлүүдэд тархаан байршуулна.
- Нөөцийг түргэн хугацаанд бэлэн валютад хувирах хөрвөх чадвар өндөртэй хөрөнгө оруулалтын хэрэгсэлүүдэд байршуулна.
- Нэг төрлийн хөрөнгө оруулалтанд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ хязгаартай байна.
- Нөөцийг хөрвүүлэх үйл ажиллагаа нь дотоодын зах зээлд аливаа сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ёстой.

5.2.2 Зах зээлийн (хүү ба валютын ханш) эрсдэлийн удирдлага:

- Монголбанк нь өөрийн хэрэгжүүлж буй бодлоготойгоо нийцүүлэн их хэмжээний зах зээлийн эрсдэл хүлээхээс зайлсхийнэ.
- Нийт хөрөнгө оруулалтын багцаас хүлээх зах зээлийн эрсдэл нь өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй байна. Зах зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулалтын үргэлжлэх хугацаа, стоп лосс лимит, VaR лимитээр тус тус тогтооно.

5.2.3 Зээлийн (харилцагч ба хөрөнгө оруулалт) эрсдэлийн удирдлага:

- Монголбанк нь өөрийн эрсдэл хүлээх чадвар, үр өгөөжийн түвшинг харгалзан зохистой бус зээлийн эрсдэлээс зайлсхийнэ.

- Улс орноор, хөрөнгө оруулалтаар, харилцагч байгууллагуудаар, зэрэглэлээр тус тус лимит тогтоон нөөцийг гадаадын төв банк, олон улсын байгууллага, өндөр зэрэглэлтэй банк, санхүүгийн байгууллагуудад тархаан байршуулна.
- Зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор зээлийн эрсдэлээс хамгаалах хэрэгсэлүүд (баталгаа гэх мэт), бүртгэл, төлбөр тооцооны гэрээ, хэлцлүүдийг (delivery vs payment, payment vs payment зэрэг төлбөр тооцооны хэрэгсэлүүд гэх мэт) ашиглана.

5.3 Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ зайлшгүй шаардлагатай лимитүүдийг тогтоож, хяналт тавина.

ЗУРГАА. Хөрөнгө оруулалтын багцын удирдлага

6.1 Монголбанкны Ерөнхийлөгчийн тогтоосон бүтцийн хүрээнд хөрөнгө оруулалтын багцын удирдлагыг идэвхитэй ба идэвхигүй гэсэн 2 хэлбэрээр хэрэгжүүлж болно. Хөрөнгө оруулалтыг идэвхитэй хэлбэрээр удирдаж байгаа тохиолдолд хөрөнгө оруулалтын багцын гүйцэтгэлийг холбогдох жишиг хэмжүүртэй харьцуулан тооцно. Идэвхитэй хэлбэрээр удирдах хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн нэг төрлийн санхүүгийн хэрэгсэлийн 10 хувиас хэтрэхгүй байна.

6.2 Монголбанк нь өөрийн нөөц боломжийн дагуу удирдах боломжгүй хөрөнгө оруулалтын салбарт нөөцийг байршуулах, мөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор олон улсын санхүүгийн байгууллага, гадаадын банк, санхүүгийн байгууллагад нөөцийн тодорхой хэсгийг багцаар удирдах эрхийг шилжүүлж болно. Энэ тохиолдолд тухайн банк, санхүүгийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц, зах зээлд эзлэх байр суурь, санхүүгийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын бодлого, дадлага туршлага, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар зэргийг харгалзан үзнэ. Мөн тухайн банк, санхүүгийн байгууллага нь аливаа эрсдэл гарах үед даах хэмжээний өөрийн хөрөнгө буюу холбогдох даатгалтай байх ёстой. Нөөцийг удирдуулах гадаадын банк, санхүүгийн байгууллагыг олон улсад тендер зарлах замаар сонгохгүй. Гадаадын банк, санхүүгийн байгууллагаар удирдуулах хөрөнгө оруулалтын багцын хэмжээ нь нийт нөөцийн 10 хувиас хэтрэхгүй байна.

ДОЛОО. Харилцагч байгууллага

7.1 Хөрөнгө оруулалт ба арилжааны үйл ажиллагаанд хамтран ажиллах байгууллага.

Зөвхөн төв банк, олон улсын байгууллага, өндөр зэрэглэлтэй гадаад орны банк, санхүүгийн байгууллага, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэдэг байгууллагыг Монголбанкны харилцагч байгууллагаар сонгоно. Харилцагч байгууллагын жагсаалтыг хөрөнгө оруулалтын багц бүрээр улирал бүр батлуулан мөрдөнө.

Харилцагч байгууллагын тоог харьцангуй багасгах тохиолдолд банк, санхүүгийн байгууллагуудын чухал харилцагчдыг харгалзан үзнэ. Мөн жагсаалтанд үлдээхдээ банк, санхүүгийн байгууллага нь гүйлгээ хийх үед зах зээлийн сайн үнийг санал болгох баталгааг харгалзан үзнэ.

7.2 Үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэгч байгууллага. (Custodians)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн үнэт цаасыг зөвхөн төв банк ба олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэдэг байгууллагад байршуулна. Үнэт цаасны төлбөр тооцоо нь delivery versus payment хэлбэрээр хийгдэнэ. Үнэт цаасны төлбөр тооцоо гүйцэтгэдэг байгууллагыг сонгохдоо үйлчилгээний шимтгэл, үйлчилгээний чанар, төлбөр тооцоо гүйцэтгэдэг ил тод байдал зэргийг харгалзан үзнэ.

НАЙМ. Нөөцийн тайлан

- 8.1 Монголбанк нь нийт гадаад актив, нийт гадаад пассив, цэвэр нөөцийн хэмжээг улирал бүр өөрийн интернет хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 8.2 Монголбанк нь хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын зарчмууд, нөөцийн удирдлагын үйл ажиллагаатай холбоотой тухайн жилд болсон гол үйл явдлуудыг жилийн тайланд тусгаж тайлагнана. Мөн нөөцийн бүрэлдэхүүн хэсгүүд, эрсдэлийн үндсэн үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг тус тус тусгасан байна.

ЕС. Нөөцийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц

- 9.1 Монголбанкны Ерөнхийлөгч нөөцийн ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавина.
- 9.2 Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч нь хөрөнгө оруулалтын бодлого болон эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавина.
- 9.3 Монголбанкны дэд Ерөнхийлөгч нь нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавина.
- 9.4 Монголбанкны Захирлуудын зөвлөл нөөцийн ерөнхий удирдлагын асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчид санал, зөвлөмж өгч болно.
- 9.5 Хөрөнгө оруулалтын хороо нь нөөцийн удирдлагын хүрээнд тухайн жилд баримтлах бүтцийг тогтоох, түүнийг хэрэгжүүлэх явцад Монголбанкны Ерөнхийлөгчөөс гаргах шийдвэрт мэргэжлийн зөвлөмж өгч, санал боловсруулна.
- 9.6 Эрсдэлийн удирдлагын алба нь хөрөнгө оруулалтын бодлогын талаар санал боловсруулах, бүх төрлийн эрсдэлийг тодорхойлон тогтоож, хяналт тавих асуудлыг хариуцан хэрэгжүүлнэ.

- 9.7 Валют, эдийн засгийн газар нь нөөцийн өдөр тутмын удирдлагыг хариуцан хэрэгжүүлнэ.
- 9.8 Төлбөр тооцоо, бүртгэлийн газар нь нөөцийн удирдлагатай холбоотой төлбөр тооцоо, бүртгэлийн бүх үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлнэ.

АРАВ. Нөөцийн удирдлагад оролцогч талуудын эрх, үүрэг

10.1 Нөөцийн удирдлагын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

- 10.1.1 Нөөцийн удирдлагын зорилго, хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын бодлого, зарчмууд, зохион байгуулалтын бүтцийг тогтооно.
- 10.1.2 Нөөцийн удирдлагатай холбогдолтой журам, зааврыг батална.
- 10.1.3 Нөөцийн бүтэц, хазайж болох дээд доод хэмжээг батална.
- 10.1.4 Нөөцийг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимитийг батална.
- 10.1.5 Арилжаалах, хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийн төрөл, нийт болон тус бүрийн хэмжээг тогтооно.
- 10.1.6 Нөөцийн нийт нээлттэй позицитай лимитийг валют, арилжааны хэрэгсэл тус бүрээр тогтооно.
- 10.1.7 Нөөцийн болзошгүй алдагдлын нийт хэмжээг тогтооно.
- 10.1.8 Үнэт металл цэвэршүүлэх байгууллага, цэвэршүүлэх нөхцөлийг батална.
- 10.1.9 Нөөцийн удирдлагыг хангахад шаардлагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, хэлэлцээ хийх удирдамж батлах, эрх олгоно.
- 10.1.10 Нөөцийн удирдлагын гүйцэтгэлд жилийн турш хяналт тавина.

10.2 Тэргүүн дэд Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхтэй:

- 10.2.1 Монголбанкны Ерөнхийлөгчийн эзгүйд энэхүү журмын 10.1-д дурьдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
- 10.2.2 Хөрөнгө оруулалтын бодлого ба эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэнд хяналт тавьж, улирал бүр дүгнэнэ.
- 10.2.3 Нөөцийн батлагдсан бүтэц, лимитүүдийн биелэлтэд өдөр бүр хяналт тавина.

10.3 Дэд Ерөнхийлөгч нь нөөцийн удирдлагын өдөр тутмын үйл ажиллагааны хэрэгжилтэнд хяналт тавина.

10.4 Монголбанкны Захирлуудын зөвлөл нь шаардлагатай тохиолдолд нөөцийн удирдлагын асуудлуудаар Монголбанкны Ерөнхийлөгчид санал оруулах, зөвлөмж өгөх эрхтэй.

10.5 Хөрөнгө оруулалтын хороо дараахь бүрэн эрхтэй:

10.5.1 Нөөцийн удирдлагын хүрээний асуудлуудыг тодорхойлоход Монголбанкны Ерөнхийлөгчийг мэргэжлийн зөвлөмжөөр хангаж, санал боловсруулах,

10.5.2 Зах зээлийн өөрчлөлттэй уялдуулан батлагдсан бүтцийн хүрээнд гарах өөрчлөлтөөр шийдвэр гаргах.

10.6 Эрсдэлийн удирдлагын албаны (дундын алба) захирал дараахь үүрэгтэй:

10.6.1 Хөрөнгө оруулалтын болон эрсдэлийн удирдлагын талаар баримтлах бодлогын талаар санал боловсруулах,

10.6.2 Хөрөнгө оруулалтын явцад хүлээж болох эрсдэлийг тодорхойлох, үнэлгээ өгөх замаар эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөхүйц түвшинд гадаад валютын нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх үндсэн чиглэл, заавар журам боловсруулах,

10.6.3 Нөөцийг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагыг сонгох зарчим, тэдгээрт тавих нөхцөл шаардлага, лимит олгох зарчмын талаар журам, заавар боловсруулах,

10.6.4 Нөөцийн бүтэц, хазайж болох дээд доод хязгаар, шаардлагатай лимитүүдийн талаар санал боловсруулах,

10.6.5 Нөөцийг байршуулах гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимитийн талаар санал боловсруулах, харилцагч гадаадын банк, санхүүгийн байгууллагын санхүү, төлбөрийн чадварт гарч байгаа өөрчлөлтийг байнга хянах,

10.6.6 Нөөцийн бүтэц, лимитийн хэрэгжилтэнд өдөр бүр хяналт тавих, удирдлагуудыг мэдээллээр хангах, шаардлагатай үед арга хэмжээ авах санал боловсруулах,

10.6.7 Нөөцийн үр өгөөжийг улирал бүр тооцож танилцуулах,

10.6.8 Нөөцийн удирдлагатай холбоотой асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулахад эрсдэлийн талаас санал өгөх,

10.6.9 Санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг судлаж, танилцуулж байх.

10.7 Валют, эдийн засгийн газрын захирал дараахь үүрэгтэй:

10.7.1 Нөөцийн удирдлагын өдөр тутмын удирдлагыг батлагдсан бүтцийн дагуу хэрэгжүүлэх,

10.7.2 Нөөцийн бүтэц, лимитийн хэрэгжилтийг өдөр бүр хангаж ажиллах,

10.7.3 Тухайн үеийн хэрэгцээ, шаардлага, орох, гарах урсгалыг харгалзан батлагдсан бүтцийн хүрээнд нөөцийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг алдагдуулахгүйгээр хянаж зохицуулах,

10.7.4 Нөөцийг шинээр хөрөнгө оруулалтанд байршуулах, сунгах, хаах зөвшөөрөл өгөх, ингэхдээ харилцагч банк, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын төрөл, валют, хугацаа, хэмжээний талаар шийдвэр гаргах,

10.7.5 Арилжаа хийх зөвшөөрөл өгөх,

10.7.6 Арилжааны нийт нээлттэй позицийн лимитийг арилжааны мэргэжилтэн тус бүрт валют, активын төрөл, санхүүгийн хэрэгсэл нэг бүрээр хуваарилж, улирлаар мөрдүүлэх,

10.7.7 Гадаад арилжааны болзошгүй алдагдлын лимитийг арилжааны мэргэжилтэн тус бүрт арилжааны төрөл, хэрэгслээр батлагдсан нийт лимитэд багтаан хуваарилж, улирлаар мөрдүүлэх,

10.7.8 Үнэт металл цэвэршүүлэх харилцагч байгууллага, ачуулах хэмжээг тухай бүр шийдвэрлэх,

10.7.9 Нөөцийн удирдлагын асуудлаар Монголбанкны Ерөнхийлөгчөөс баталсан удирдамжийн дагуу хэлэлцээ хийж, түүнээс олгосон эрхийн дагуу гэрээ, хэлцэл байгуулах.

10.8 Валют, эдийн засгийн газрын санхүүгийн зах зээлийн хэлтэс (арилжааны алба) дараахь ажлыг эрхэлнэ:

10.8.1 Батлагдсан журам, зааврын дагуу, холбогдох зөвшөөрлийн хүрээнд тодорхой харилцагч банк, байгууллагад хөрөнгө байршуулах, сунгах, хаах хэлцэл хийх,

10.8.2 Батлагдсан журам, зааврын дагуу, зохих лимитийн хүрээнд арилжааны хэлцэл хийх,

10.8.3 Хэлцлийн гүйцэтгэлийг хангахад шаардлагатай бүхий мэдээллийг Бүртгэлийн хэлтэст шуурхай өгөх,

10.8.4 Валютын ханш, хүү, үнэт металлын үнийн төлөв хандлага, эдгээрт нөлөөлөх эдийн засаг, улс төр болон бүтцийн өөрчлөлтийн хүчин зүйлсийг тогтмол судлах,

10.8.5 Олон улсын санхүүгийн зах зээлд гарч байгаа өөрчлөлт, хөрөнгө оруулалтын шинэ хэрэгсэл, дэвшилттэй зүйлийг судалж, санал боловсруулах,

10.8.6 Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг судлаж, танилцуулж байх,

10.8.7 Нөөцийн худалдан авах чадвар, үр өгөөжид нөлөөлөх зах зээлийн өөрчлөлт, хөдөлгөөнийг судалж, холбогдох этгээдэд тухай бүр мэдээлэх.

10.9 Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын Бүртгэлийн хэлтэс (арын алба) дараахь үйл ажиллагаа эрхэлнэ:

10.9.1 Зохих журмын дагуу зөвшөөрөгдөж хийгдсэн хэлцлийн баталгааг харилцагчид шуурхай хүргүүлэх,

10.9.2 Хөрөнгө оруулалтын болон арилжааны хэлцлийн гүйлгээг цаг тухайд нь зохих журмын дагуу хийх, нягтлан бодох бүртгэлд тусгах,

10.9.3 Хэлцлийн биелэлтэд бүртгэлээр хяналт тавих,

10.9.4 Хөрөнгө оруулалтын болон арилжааны мэдээ, тайланг зохих журмын дагуу гаргаж өгөх,

10.9.5 Лимитийн биелэлтийн мэдээг зохих журмын дагуу гаргаж өгөх.

10.10 Мэдээллийн технологийн газар дараахь ажлыг эрхэлнэ:

10.10.1 Нөөцийн удирдлагын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, сүлжээ, программ хангамжаар хангах, байнгын бэлэн байдалд байлгах,

10.10.2 Нөөцийн удирдлагатай холбогдох мэдээ тайланг үнэн зөв гаргах программ хангамжийг боловсруулах.

10.11 Дотоод аудитын газар дараахь ажлыг эрхэлнэ:

10.11.1 Нөөцөд жилд нэгээс доошгүй удаа аудитын дүгнэлт хийх,

10.11.2 Нөөцөд гадаадын хөндлөнгийн аудитын байгууллагаар аудитын дүгнэлт хийлгүүлэх ажлыг зохион байгуулах.

АРВАН НЭГ. Хариуцлага

11.1 Энэхүү журмын зөрчил эрүүгийн гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлнэ.

11.2 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Танилцуулга

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журмыг шинэчлэх тухай

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Гадаад валютын нөөцийн удирдлагын журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 11 сарын 14-ны өдрийн 553 дугаар тушаалаар баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд 5 удаа дараахь нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан байна. Үүнд:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2004 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 15 дугаар бүхий тушаалаар нөөцийг байршуулах хөрөнгө оруулалтанд Монгол улсад бодитоор хөрөнгө оруулсан, түүнчлэн уламжлалт харилцаатай бүс нутгийн болон гадаадын банк санхүүгийн байгууллагууд дахь хадгаламж, үнэт цаасыг оруулахаар болсон байна.
2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2005 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 147 дугаар бүхий тушаалаар нийт нээлттэй цэвэр позиц, тухайн нэг гадаад валют, нэг төрлийн санхүүгийн хэрэгсэлийн нээлттэй позицгийг Монголбанкны дүрмийн сан бус өөрийн хөрөнгийн тодорхой хувиар хязгаарлах, мөн гадаад арилжааны нийт стоп лосс лимит, арилжааны албаны стоп лосс лимит, нэг хэлцлийн стоп лосс лимитийг тодорхой хэмжээгээр тогтоож өгсөн байна.
3. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 22 дугаар бүхий тушаалаар нөөц активын ерөнхий бүтэц болон нөөцийг байршуулахад баримтлах лимитийн бүтцийг сайжруулах зорилгоор журмын хавсралтуудыг шинэчлэн баталсан болно. Мөн “Нөөцийн 50-иас доошгүй хувийг 6 сараас илүүгүй хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулна” гэсэн заалтыг “1 жил хүртэл хугацаатай нийт активын 50-иас доошгүй хувийг 6 сараас илүүгүй хугацаатай активт байршуулна” гэж өөрчилсөн байна. Мөн нөөцийг байршуулах гадаад орны засгийн газрын үнэт цаасны зэрэглэлийг AAA-аас AA зэрэглэлтэй засгийн газрууд байсныг AAA-аас A+ болгож өргөжүүлсэн байна.
4. Хөрөнгө оруулалтын хороо, Эрсдэлийн удирдлагын албыг байгуулсантай холбоотой Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 615 дугаар бүхий тушаалаар нөөцийн удирдлагын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулсан. Уг өөрчлөлтөөр Хөрөнгө оруулалтын хороо болон Эрсдэлийн удирдлагын албаны ажлын чиг үүргийг тодорхойлж өгсөн.

5. Эрсдэлийн удирдлагын албаны саналыг үндэслэн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2008 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 02 дугаар бүхий тушаалаар журмын хавсралтуудыг шинэчлэн баталсан.

Тус журманд орсон сүүлийн өөрчлөлтүүдийн хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон нөөцийн удирдлагын зохион байгуулалтын бүтэц зэрэг гол асуудлуудыг хамарсан байна. Хөрөнгө оруулалтын бодлого болон зохион байгуулалтын өөрчлөлтүүд, зарим нэг заалтыг илүү тодорхой болгох шаардлагын дагуу тус журмыг нийтэд нь шинэчлэн боловсруулах шаардлага гараад байна.

“Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журам” нь 11 зүйлтэй байхаар шинэчлэн боловсрууллаа. Өмнөх журамтай харьцуулахад дараахь гол өөрчлөлтүүд орсон болно. Үүнд:

1. Гадаад валютын нөөцийн удирдлагын зорилго, хөрөнгө оруулалтын бодлого түүний зарчим, хөрөнгө оруулалтын хэрэгсэл, эрсдэлийн удирдлага, нөөцийн тайлан, зохион байгуулалтын бүтэц зэрэг асуудлуудыг илүү тодорхой болгосон.
2. Өмнөх журманд тусгагдаагүй байсан зарим асуудлууд болох хөрөнгө оруулалтын багцын удирдлага, харилцагч байгууллага зэрэг асуудлуудыг нэмж тусгасан.
- 3.